



УИХ-аас ирүүлсэн хариу

2026.07.24
№УИХ-01/8736

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХЭРЭГЖСЭН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ

УИХ-ын Тамгын газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хооронд 2017 оны 02 дугаар сарын 17-ны өдөр бизнесийн хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд хамтран ажиллах тухай Хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан билээ. Санамж бичгийн хүрээнд шат дараатай үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн бөгөөд өнгөрөгч 05 дугаар сарын 27-ны өдөр УИХ-ын дарга С.Бямбацогт МҮХАҮТ-ын Удирдах зөвлөл, бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтын үеэр бизнесийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагын талаар санал солилцож, ажил хэрэгч хэлэлцүүлэг өрнүүлсэн.

МҮХАҮТ уулзалтын үеэр бизнес эрхлэгчдээс гаргасан санал хүсэлтийг нэгтгэн үндсэн гурван чиглэл бүхий асуудлыг тусгасан албан бичгийг УИХ-ын даргад хүргүүлсний дагуу УИХ-ын дарга С.Бямбацогт бизнесийн хууль эрх зүйн хүрээнд хийгдсэн шинэчлэлийн талаарх мэдээллийг ирүүлэв.

УИХ-ын 2026 оны хаврын ээлжит чуулганаар нийгэм эдийн засаг, иргэдийн амьдралд тулгамдсан, олон жил шийдэгдэж чадахгүй байсан нэн чухал хууль тогтоомжуудыг хэлэлцэн баталсны дотор бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн эрх чөлөөг бэхжүүлэхэд чиглэсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтүүд, бизнес эрхлэгчдийг дэмжих, иргэдийн оролцоог хамгаалах Татварын багц хууль, ажил олгогчийн ачааллыг бууруулж, нийгмийн хамгааллыг сайжруулах Нийгмийн даатгалын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг баталсан. Ингэснээр МҮХАҮТ-аас хүргүүлсэн санал хүсэлтийн тодорхой хэсэг хууль эрх зүйн шийдэлд тусгалаа олж, эхний үр дүн гарч эхлээд байна.

Улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, баялаг бүтээж буй хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, чөлөөт эдийн засгийн суурийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн эдгээр шинэчлэлүүд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг болно гэдэгт итгэж байна.

МУХАҮТ-ААС УИХ-Д ХҮРГҮҮЛСЭН САНАЛ, ХҮСЭЛТИЙН ҮР ДҮН

Үндсэн 3 чиглэл



1. ТАТВАР, САНХҮҮ, НДШ

ГОЛ АСУУДАЛ

- Татварын дарамтыг бууруулах
- НӨАТ-ын босгыг оновчтой болгох
- Шаталсан татварын тогтолцоо
- Зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх
- НДШ-ийн ачааллыг бууруулах



ҮР ДҮН: ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, татварын ачааллыг бууруулав.
- ААН, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулав.
- Нийгмийн даатгалд анх удаа хамрагдаж буй иргэдийг дэмжив.
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжив.
- НД-ын шимтгэл төлөх нөхцөлийг уян хатан болгов.
- Ажил олгогчийн шимтгэлийн ачааллыг бууруулав.
- Тэтгэвэр тогтоолгох насны уян хатан зохицуулалт зэрэг олон нэмэлт өөрчлөлт оруулсан.



2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, БИЗНЕСИЙН ОРЧИН

ГОЛ АСУУДАЛ

- Зөвшөөрөл, лицензийн хүндрэл
- Хуулийн тогтворгүй байдал
- Төрийн хяналт, дарамтыг бууруулах
- Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих
- Мэргэшсэн ажиллах хүчний хомсдол



ҮР ДҮН: ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Төр гэнэтийн шийдвэр гаргахгүй, бизнесийн үйл ажиллагааг урьдчилан төлөвлөх боломж бүрдэв.
- Төрийн зохицуулалт, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгож, хүндрэлийг бууруулав.
- Төрийн байгууллагууд иргэн, хуулийн этгээдээс нэг мэдээллийг давтан шаардахгүй байхаар зохицуулав.
- Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах зэрэг чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт орсон.



3. ТЕХНОЛОГИ, ИННОВАЦ, ЭКСПОРТ

ГОЛ АСУУДАЛ

- Хууль эрх зүйн орчны шинэчлэл
- Хиймэл оюун ухаан нэвтрүүлэх
- Дижитал шилжилтийг хурдасгах
- Экспортын дэмжлэг, худалдааг хөнгөвчлөх
- Арилжааны тухай хуулийн шинэчлэл



ҮР ДҮН: ГОЛ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Хиймэл оюуныг худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ашиглаж болохоор зохицуулав.
- Гадаадын иргэн, аж ахуйн нэг Монгол Улсад оршин суухгүйгээр цахим хэлбэрээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтой болсон.
- Дата төв болон хиймэл оюун ухааны зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн албан татварын хөнгөлөлтөд хамруулж, дэвшилтэт технологи, хүнс, аялал жуулчлалын салбарт ажиллах гадаад мэргэжилтний ажлын байрын төлбөрөөс төлөөлөхөөр зохицуулав.

УИХ-аас ирүүлсэн хариу Дэлгэрэнгүй



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон,
Утас: 26-70-10, Факс: 32-70-16
E-mail: secretariat@parliament.mn
http://www.parliament.mn

2026.07.24 № УИХ-01/8936

танай _____-ны № _____-т

Хариу хүргүүлэх тухай

МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Б.ЛХАГВАЖАВ
ТАНАА

Улсын Их Хурлын даргын албан үүрэгт томилогдсоноос хойш миний бие бизнес эрхлэгчид, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийсэн анхны уулзалтаа 2026 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын Удирдах зөвлөл болон гишүүдийн төлөөлөлтэй зохион байгуулсан билээ. Уулзалтын үеэр бизнесийн салбарын өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хэрэгцээ, шаардлагын талаар санал солилцож, ажил хэрэгч хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Уулзалтын үеэр бизнес эрхлэгчдээс гаргасан санал, хүсэлтийг нэгтгэн ирүүлсэн Танай байгууллагын албан бичигт дараах үндсэн гурван чиглэлийн асуудлыг тусгасан байна. Үүнд:

1.Татвар, санхүү болон нийгмийн даатгалын дарамтыг бууруулах: Татварын тогтолцоог шударга, ойлгомжтой, тогтвортой болгож, хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн татварын хуулийн цогц шинэчлэл шаардлагатай байгааг онцолжээ. Тухайлбал, НӨАТ төлөгчөөр бүртгүүлэх босгыг өмсөхтэй тогтоох, салбарын онцлогт нийцүүлэн татварын хувь хэмжээг бууруулах, татвар ногдуулах аргачлалыг тодорхой болгох, татварын байгууллагаас аж ахуйн нэгжийн дансыг шууд битүүмжилж үйл ажиллагааг нь доголдуулах практикийг зогсоох, жижиг, дунд бизнесийн онцлогт тохирсон шаталсан татварын тогтолцоог бий болгох зэрэг саналыг ирүүлсэн байна. Түүнчлэн бизнесийн санхүүжилтийн нөхцөлийг сайжруулах хүрээнд банкны зээлийн хүүг бууруулах, зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн ачааллыг багасгах замаар ажиллах хүчний тогтвортой байдлыг хангах боломж бүрдүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэжээ.

2.Бизнесийн тогтвортой орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалт хийх боломжийг нэмэгдүүлэх: Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагаанд тулгарч буй зөвшөөрөл, зохицуулалтын хүндрэл, хууль тогтоомжийн уялдаагүй байдал, төрийн хүнд суртлыг бууруулах шаардлагатай байгааг тэмдэглэсэн байна. Мөн хөрөнгө оруулагчдад илгээвэргүй, тэгш хандах зарчмыг хэрэгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтын босгыг бууруулах, мэргэшсэн ажиллах хүчийг татан оролцуулах боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатайг онцолжээ.

3.Технологийн шинэчлэл, экспортыг дэмжих чиглэлээр эрх зүйн орчныг шинэчлэх: Хууль тогтоомжийг боловсруулах болон хэрэгжүүлэх үйл явцад хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, бизнес эрхлэгчдийн саналыг бодитой тусгах, бизнесийн харилцааг зохицуулах Арилжааны тухай хуулийг батлан мөрдүүлэх, хиймэл оюун ухаан болон дижитал технологийн салбарын хөгжилд нийцсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгааг тусгасан байна. Мөн хөдөлмөрийн бүтээмжид сөргөөр нөлөөлж болзошгүй халамжийн бодлогын хэрэгжилтийг өнөөчтэй болгох шаардлагатайг онцолжээ.

Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганаар нийгэм эдийн засаг, иргэдийн амьдралд тулгамдсан, олон жил шийдэгдэж чадахгүй байсан нэн чухал хууль тогтоомжуудыг хэлэлцэн баталсны дотор бизнес эрхлэх, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, эдийн засгийн эрх чөлөөг бэхжүүлэхэд чиглэсэн Эдийн засгийн эрх чөлөөний тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтүүд, бизнес эрхлэгчдийг дэмжих, иргэдийн орлогыг хамгаалах Татварын багц хууль, ажил олгогчийн ачааллыг бууруулж, нийгмийн хамгааллыг сайжруулах Нийгмийн даатгалын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг баталсан болно. Ингэснээр уулзалтын үеэр болон Танай байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлтийн тодорхой хэсэг хууль эрх зүйн шийдэлд тусгалаа олж, эхний үр дүн гарч эхлээд байна.

Улсын эдийн засгийн өсөлт, хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулж, баялаг бүтээж буй хувийн хэвшлийн бизнес эрхлэгчдийн өмнө тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж, чөлөөт эдийн засгийг суурийг бэхжүүлэхэд чиглэсэн хууль эрх зүйн эдгээр шинэчлэлүүд та бүхний үйл ажиллагаанд тодорхой дэмжлэг болно гэдэгт итгэж байна.

Ингээд дээрх хууль тогтоомжид тусгагдсан гол зохицуулалтуудыг товчлон хүргэж байна. Үүнд:

НЭГДҮГЭЭРТ. ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬ БОЛОН ХОЛБОГДОХ 90 ХУУЛЬД ОРУУЛСАН НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:

1.Төр гэнэтийн шийдвэр гаргахгүй, бизнесийн үйл ажиллагааг дур зоргоор хязгаарлахгүй, үнэ тогтоох үйл ажиллагаанд оролцохгүй, бизнесийн эрх чөлөөг хамгаалах чиглэлээр:

- Бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хууль тогтоомжийг батлагдсанаас хойш 6-аас доошгүй сарын дараа хүчин төгөлдөр мөрдөхөөр зохицууллаа.
- Төрийн байгууллагууд иргэн, хуулийн этгээдээс нэг мэдээллийг давтан шаардахгүй байх зохицуулалтыг бий болголоо.
- Төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлнэ.
- Хууль, захиргааны шийдвэрт жил тутам дүн шинжилгээ хийж бизнесийн үйл ажиллагааг хязгаарласан шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг хүчингүй болгоно.
- Үнэ тарифын зохицуулалттай бизнесийн үйл ажиллагааны жагсаалт, тэдгээрт төрөөс олгосон татаас, дэмжлэгийн хэмжээ, нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, үнэ тарифын зохицуулалтын үргэлжлэх хугацаа ил тод байна.
- Төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалт, худалдан авалт нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломжийг хангана.
- Хиймэл оюуныг худалдан авах ажиллагааг зохион байгуулахад ашиглаж болохоор зохицууллаа.
- Гадаадын иргэн, аж ахуйн нэгж Монгол Улсад оршин суухгүйгээр цахим хэлбэрээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх боломжтой болголоо.

2.Төрийн зохицуулалт, зөвшөөрлийн тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр:

- Эрчим хүч, санхүү, боловсролын салбар дахь 41 төрлийн зөвшөөрлийг хүчингүй болголоо.
- Барилгын салбарт үйл ажиллагаа эрхлэхэд тулгардаг олон шат дамжлагатай зөвшөөрлийн тогтолцоог хялбаршуулж, зөвшөөрөл авах хугацааг бууруулах нөхцөлийг бүрдүүллээ.
- Тусгай зөвшөөрлийг 10 жил, энгийн зөвшөөрлийг 5 жилийн хугацаатай олгож, зөрчилгүй тохиолдолд ажлын хоёр өдрийн дотор сунгахаар зохицууллаа.

УИХ-аас ирүүлсэн хариу Дэлгэрэнгүй

- Зөвшөөрөл авахад тавигддаг шаардлагын тоог бууруулж, үйлчилгээний хүртээмжийг сайжрууллаа.
- Татвар болон нийгмийн даатгалын өртэй гэх үндэслэлээр зөвшөөрлийг цуцлах, сунгахаас татгалзахыг хориглолоо.
- 120 гаруй төрлийн зөвшөөрөл олгох чиг үүргийг мэргэжлийн холбоодод шилжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүллээ.

3.Хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах чиглэлээр:

- Гадаад, дотоодын эх үүсвэрээс татан төвлөрүүлсэн зээлийн хүүгийн орлогод ногдох татварын хэмжээг 5 хувь болгон буурууллаа.
- Улаанбаатар хотод 20 тэрбум төгрөгөөс, орон нутагт 10 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалт хийсэн төсөлд 10 жилийн хугацаанд тогтворжуулах нөхцөл олгохоор тусгалаа. Харин 50 тэрбум төгрөгөөс дээш хөрөнгө оруулалтад байршлаас үл хамааран 15-20 жилийн хугацааны тогтвортой байдлын баталгааг олгоно.
- Хөрөнгө оруулагчийн гаргасан гомдол, хүсэлтийг 30 хоногийн дотор шийдвэрлэх зохицуулалтыг тусгалаа.
- Дата төв болон хиймэл оюун ухааны зориулалттай тоног төхөөрөмжийг гаалийн албан татварын хөнгөлөлтөд хамруулж, дэвшилтэт технологи, хүнс, аялал жуулчлалын салбарт ажиллах гадаад мэргэжилтний ажлын байрны төлбөрөөс чөлөөлөхөөр зохицууллаа.

ХОЁРДУГААРТ.ТАТВАРЫН БАГЦ ХУУЛИУДЫН ХҮРЭЭНД:

1.Иргэдийн орлогыг нэмэгдүүлж, татварын ачааллыг бууруулах чиглэлээр:

- Сарын 792,000 төгрөг хүртэлх цалингийн орлогыг хувь хүний орлогын албан татвараас 100 хувь чөлөөлөхөөр тусгалаа. Мөн 792,000 төгрөгөөс 2 сая төгрөг хүртэлх орлогод 1 хувийн татвар ногдуулах зохицуулалтыг 2028 оноос хэрэгжүүлнэ.
- Иргэн анх өмчилсөн орон сууцаа худалдан борлуулсан тохиолдолд үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны 2 хувийн албан татвараас чөлөөлөхөөр зохицууллаа.

2.Аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн татварын ачааллыг бууруулах чиглэлээр:

- Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ) суутган төлөгчөөр бүртгүүлэх босгыг 50 сая төгрөгөөс 400 сая төгрөг болгон нэмэгдүүллээ.
- НӨАТ төлөх хугацааг хоёр сар хүртэлх хугацаагаар хойшлуулах боломжийг бүрдүүллээ.
- Аж ахуйн нэгжүүдэд олгодог 90 хувийн татварын хөнгөлөлтийн босгыг 1.5 тэрбум төгрөгөөс 2.5 тэрбум төгрөг болгон нэмэгдүүллээ.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын шатлалыг шинэчилж, 6-10 тэрбум төгрөгийн орлоготой аж ахуйн нэгжүүдэд ногдох татварын хэмжээг 25 хувиас 15 хувь болгон буурууллаа.
- Татварын өртэй татвар төлөгчийн дансыг бүхэлд нь хаахгүй бөгөөд орж ирэх мөнгөн хөрөнгийн 30 хувийг ашиглах боломжтой байхаар зохицууллаа.
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар болон хувь хүний орлогын албан татварын тайлан гаргах хугацааг сунгаж, илүү оновчтой болголоо.
- Алдданийн дээд хэмжээг үндсэн төлбөрийн 50 хувиас хэтрэхгүй байхаар тогтоолоо.
- Татварын тайлан залруулах хугацааг хоёр жил хүртэл болгон сунгалаа.
- Виртуал бүсэд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны орлогод ногдох татварыг 100 хувь хөнгөлөхөөр тусгалаа.

ГУРАВДУГААРТ: НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАГЦ ХУУЛИУДЫН ХҮРЭЭНД:

1.Нийгмийн даатгалд анх удаа хамрагдаж буй иргэдийг дэмжих чиглэлээр:

- Албан бус салбарт ажиллагчдын ирээдүйн нийгмийн хамгааллын баталгааг бэхжүүлэх зорилгоор нийгмийн даатгалд анх удаа хамрагдаж байгаа иргэний тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг 24 сарын хугацаанд хөнгөлөхөөр тусгалаа.

2.Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр:

- Сүүлийн таван жилийн хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлсэн, тав хүртэл ажилтантай ажил олгогчийн гурван хүртэлх ажилтанд ногдох ажил олгогчийн төлөх тэтгэвэр, тэтгэмжийн даатгалын шимтгэлийг 36 сар хүртэл хугацаагаар чөлөөлнө. Хэрэв ажилтан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол энэхүү хугацаа 60 сар хүртэл үргэлжилнэ.

3.Нийгмийн даатгалын шимтгэл төлөх нөхцөлийг уян хатан болгох чиглэлээр:

- Ажил гүйцэтгэх, хөлөөр ажиллах болон түүнтэй адилтгах гэрээгээр ажиллаж байгаа иргэдэд нийгмийн даатгалын шимтгэлээ илүү уян хатан нөхцөлөөр төлөх боломж бүрдүүллээ. Тухайлбал, хэд хэдэн гэрээний үндсэн дээр ажиллаж байгаа иргэн өөрт ашигтай хоёр хүртэлх гэрээг сонгон нийгмийн даатгалд хамрагдах боломжтой болсон. Мөн үндсэн хөдөлмөрийн гэрээтэй ажилтан ажил гүйцэтгэх болон түүнтэй адилтгах гэрээгээр нэмэлт ажил эрхлэх тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл давхар төлөхгүй байх боломжийг бүрдүүллээ.

4.Ажил олгогчийн шимтгэлийн ачааллыг бууруулах чиглэлээр:

- Ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэлд тооцож цалин хөлсний сан болон түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээнд үе шаттайгаар хязгаар тогтоохоор зохицууллаа. Үүнд, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2028 онд 12 дахин, 2029 онд 11 дахин, 2030 оноос эхлэн 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байхаар тусгасан.

5.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг бууруулах чиглэлээр:

- Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагааны нөхцөл болон ажлын байрны эрсдэлийн түвшнээс хамаарч ногдуулдаг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 0.5, 1.5, 2.5 хувиас 0.3, 1.2, 2.2 хувь болгон тус тус буурууллаа.

6.Ажил хөдөлмөр эрхэлж буй оюутан, суралцагчдыг дэмжих чиглэлээр:

- Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, политехник коллеж, их сургууль, коллежийн дэд бакалавр болон бакалаврын түвшний хөтөлбөрт суралцаж байгаа 15-24 насны суралцагчид өөрийн хүсэлтээр нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөгдөх боломжтой боллоо. Чөлөөлөгдсөн хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэлийг 26 нас хүрэхээсээ өмнө нөхөн төлөх эрхтэй байхаар зохицуулсан. Харин ажил олгогч нь зөвхөн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэл төлнө.

7.Тэтгэвэр тогтоолгох насны уян хатан зохицуулалтыг бий болгох чиглэлээр:

- Тэтгэврийг өрдийн наснаас хойш тогтоолгосон тохиолдолд тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, харин өрдийн наснаас өмнө тогтоолгосон бол бууруулан тооцох зохицуулалтыг тусгалаа.

8.Тэтгэврийн хуримтлал үүсгэх боломжийг нэмэгдүүлэх чиглэлээр:

- Даатгуулагч өөрийн хүсэлтээр тэтгэврийн даатгалын шимтгэлийн 1 хувийг хуримтлуулах тохиолдолд улсын төсвөөс тухайн хуримтлалын 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг 120 сар хүртэл хугацаанд олгох боломжийг бүрдүүллээ.

Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж нь амьдрал практикт бодитоор хэрэгжж, иргэд, аж ахуйн нэгжүүдэд үр өгөөжөө өгөх нь нэн чухал юм. Иймд Засгийн газар хууль тогтоомжийн хэрэгжилтэд онцгой анхаарч, бодлогын үр дүнг иргэд, олон нийт болон бизнесийн салбарт бодитоор мэдрэгдэхүйц түвшинд хүргэж ажиллахыг Улсын Их Хурлын даргын зүгээс тогтмол анхааруулж, шаардлага тавьж ажиллах болно. Бизнес эрхлэгч Та бүхэн цаашид ч хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, санал бодлоо идэвхтэй илэрхийлэн, төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх үйл хэрэгт хамтран ажиллана гэдэгт итгэл төгс байна.

Хүндэтгэсэн,

